

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

***Хуралдааны товч тэмдэглэл:*** 1-2

***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*** 3-4

---

*1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
4 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 45 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд;  
Чөлөөтэй: Ц.Сандаг-Очир, Л.Гантөмөр, Ц.Идэрбат, Н.Номтойбаяр, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан;  
Эмнэлгийн чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, А.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Г.Уянгахишиг;  
Тасалсан: Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 05 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 50 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
15 цаг 45 минут.

### **ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Зулпхар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан эхэлсэн, нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Байнгын хорооны хуралдаанд Аюушийн Ариунзаяа, Жигжидийн Батжаргал, Энхбатын Болормаа, Сархадын Сулпхар, Бөхчулууны Пүрэвдорж, Өлзийхүүгийн Шижир, Жадамбын Бат-Эрдэнэ, Баярмагнайн Баярбаатар, Сандагийн Бямбацогт, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ням-Осорын Учрал, Доржзовдын Энхтуяа, Батын Батбаатар, Жудагийн Баярмаа, Цэрэнпилийн Даваасүрэн, Чинбатын Номин, Бадарчийн Хэрлэн нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдаанд гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн учир хуралдааны ирц бүрдсэн байна. Хуралдааны ирц 53,1 хувьтай.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1 дүгээрт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг бид явуулна.

2 дахь асуудал байгаа юм. 2 дахь асуудал маань чуулганы хуралдаанаас нэгдсэн хуралдаанаас Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан тогтоолын төсөл батлагдсаны дараа энэ асуудлыг хэлэлцэх учраас энэ 2 дахь асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас авч байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? 1 дүгээрт, 2 дахь асуудлыг түр хойшлууллаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хороодын гишүүдээс санал байхгүй. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж эхэлье. Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Эцсийн энэ танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга. Монгол

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүдээс 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2026 оны 4 дүгээр сарын 09, 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт явуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулж байна. Тус Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олонхын дэмжлэг авсан саналыг нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг уншиж танилцууллаа. Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байхгүй.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, би өөр бас маргааш танилцуулах юм, давхцах гээд байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна.

15.50 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА